



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 32

Хараат

Төсөл сонгон шалгаруулах хорооны
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих жухам”-ын 3.3.2, 4.2-д заасныг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл сонгон шалгаруулах хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Хорооны дарга: Ш.Мөнх-Оргил /Засаг Даргын Тамгын Газрын дарга/

Нарийн бичгийн дарга: Б.Цэрэнмаа /Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн/

Гишүүд: Ж.Чулуунтогтох /Нягтлан бодогч/

Д.Амармэнд /Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл/

Т.Өлзийжаргал /Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл/

Хоёр. Төслийг журмын дагуу сонгон шалгаруулж, иргэдийн оролцоог хангах, гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн явц, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд хагас, бүтэн жилээр тайлагнахыг хорооны дарга /Ш.Мөнх-Оргил/-д даалгасугай.

ДАРГА  Т.ТҮМЭНДЭЛГЭР

